



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022. оны 08 сарын 03 өдөр

Дугаар 4/157

Улаанбаатар хот

Ээлжийн амралтын хуваарь батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйл, 110 дугаар зүйл, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2021 оны А/110 дугаар “Орлон ажиллах тухай” тушаал, 2021 оны А/283 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Ажилтан, албан хаагчдын 2022 оны 08 дугаар сарын ээлжийн амралтын хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Ээлжийн амралтаа эдэлж буй албан хаагчдын ажлыг цалгардуулахгүй тухай бүр зохицуулалт хийж ажиллахыг газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Коронавирус (КОВИД-19)-ын цар тахлын шар түвшинд байгаа тул халдвараас өөрийгөө болон бусдыг хамгаалах үүргээ ухамсарлан дагаж мөрдөх дүрэм журмыг сайтар сахих, ажлын зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд гар утас унтраахгүй, дуудсан цагт тайлбар өгөлгүй бэлэн байхыг нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.

4. Албан хаагчдын ээлжийн амралтын олговрыг зохих журмын дагуу тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Дугармаа)-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГА  Д.НАРАНТУЯА

1422 010157